



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 470

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 4.6, 4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба (хуучнаар)-ны нэр дээр бүртгэлтэй боловч тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэгдээгүй орхигдсон, хавсралтад заасан 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн үнэ бүхий 1 өрөө орон сууцны байрыг Хилийн цэргийн 0108 дугаар ангид эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Бригадын генерал Х.Лхагвасүрэн, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн захирагч, хурандаа В.Намхайнямбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх, Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдэгдэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны ..... дугаар сарын ..... ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХИЛИЙН ЦЭРГИЙН 0108 ДУГААР АНГИД ЭЗЭМШҮҮЛЖ  
ТӨРИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ /ОРОН СУУЦ

№	Хөрөнгийн нэр, хаяг байршил	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Орон сууцны хэмжээ (метр квадрат)	Хөрөнгийн дүн /төгрөг/
1	Дорноговь аймгийн Замын-Үүд сум, өрөө орон сууцны 114 дүгээр байшин 17 тоот 1 өрөө орон сууцны байр	2009	1	17,3 метр квадрат (хуучин хэмжилт)	20,000,000.00
НИЙТ ДҮН					20,000,000.00 (хорин сая)